



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2026/086/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитор Л.Соёлмөнх

Утас: 7033-3019

Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.01.29 № 01

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН
ЦАХИР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Х.ОТГОН-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны 1 хөтөлбөр 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 225,911.5 мянган төгрөгийн санхүүжилт эх үүсвэрийг авч, гүйцэтгэлээр 199,998.6 мянган төгрөгийг зарцуулж, 25,912.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	264,000.00	1,126,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	264,000.00	1,126,500.00
354	Хангамжийн материал	264,000.00	1,126,500.00
35410	Бичиг хэргийн материал	101,500.00	779,000.00
35420	Аж ахуйн материал	162,500.00	162,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	185,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	56,780,056.83	51,220,375.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	56,780,056.83	51,220,375.20
392	Биет хөрөнгө	56,671,723.42	51,137,041.78
39203	Авто-тээврийн хэрэгсэл	60,000,000.00	60,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,000,000.00)	(15,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,985,000.00	15,075,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,532,416.59)	(9,142,248.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	258,840.00	258,840.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,699.99)	(55,449.99)
393	Биет бус хөрөнгө	108,333.41	83,333.42
39301	Программ хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(191,666.59)	(216,666.58)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	57,044,056.83	52,346,875.20
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	133,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	133,000.00	-
413	Өглөг	133,000.00	-
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	133,000.00	-
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	56,911,056.83	52,346,875.20
51	Засгийн газрын хувь оролцоо	56,911,056.83	52,346,875.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	679,000.00	679,000.00
51101	Өмч: - төрийн	679,000.00	679,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	56,207,179.53	51,642,997.90
51210	Өмнөх үеийн үр дүн	5,093,089.03	56,207,179.53
512200	Тайлант үеийн үр дүн	51,114,090.50	(4,564,181.63)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,877.30	24,877.30
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	57,044,056.83	52,346,875.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	252,547,100.00	226,911,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	60,560,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	60,560,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	60,560,000.00	-
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	60,560,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	191,987,100.00	226,911,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	191,987,100.00	225,911,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	191,987,100.00	225,911,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	201,202,176.31	231,475,681.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	201,202,176.31	231,475,681.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	179,569,744.42	205,062,794.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	118,537,924.84	143,718,022.20
210101	Үндсэн цалин	76,789,159.44	88,760,771.99
210102	Нэмэгдэл	33,495,891.40	51,533,257.71
210104	Урамшуулал	8,252,874.00	3,423,992.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,753,279.27	18,057,900.92
210201	Тэтгэврийн даатгал	10,158,933.68	12,279,372.45
210202	Тэтгэмжийн даатгал	1,114,138.05	1,444,632.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	843,144.03	722,316.07
210204	Ажилгүйдлийн даатгал	266,135.43	722,316.07
210205	Эрүүл мэндийн даатгал	2,370,928.08	2,889,264.23
2104	Хангамж, бараа материалын зардал	17,094,170.00	13,871,690.00
210401	Бичиг хэрэг	4,964,310.00	4,348,050.00
210402	Тээвэр, шатахуун	11,935,360.00	8,734,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	788,800.00
210404	Ном, хэвлэл	194,500.00	-
2107	Томилолт, зочны зардал	3,836,000.00	2,760,000.00
210702	Дотоод албан томилолт	3,836,000.00	2,760,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	607,294.00	10,596,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	582,950.00	10,525,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	17,544.00	22,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	6,800.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,741,076.31	16,058,681.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,205,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,705,500.00	5,202,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,035,576.31	9,650,581.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,632,431.89	26,412,886.88

2132	Бусад урсгал шилжүүлэг	10,832,000.00	500,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,582,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,250,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,800,431.89	25,912,886.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,800,431.89	25,912,886.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>51,344,923.69</u>	<u>(4,564,181.63)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	230,833.19	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	230,833.19	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	230,833.19	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>51,575,756.88</u>	<u>(4,564,181.63)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>191,987,100.00</u>	<u>226,911,500.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>191,987,100.00</u>	226,911,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	191,987,100.00	225,911,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	191,987,100.00	225,911,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>191,987,100.00</u>	<u>222,820,600.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,987,100.00	222,820,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	170,354,668.11	196,407,713.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	118,537,924.84	143,718,022.20
210101	Үндсэн цалин	73,777,859.44	88,760,771.99
210102	Нэмэгдэл	36,507,191.40	51,533,257.71
210104	Урамшуулал	8,252,874.00	3,423,992.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,753,279.27	18,057,900.92
210201	Тэтгэврийн даатгал	10,158,933.68	12,279,372.45
210202	Тэтгэмжийн даатгал	1,114,138.05	1,444,632.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	843,144.03	722,316.07
210204	Ажилгүйдлийн даатгал	266,135.43	722,316.07
210205	Эрүүл мэндийн даатгал	2,370,928.08	2,889,264.23
2104	Хангамж, бараа материалын зардал	15,630,620.00	12,981,220.00
210401	Бичиг хэрэг	4,918,000.00	3,470,900.00
210402	Тээвэр, шатахуун	10,518,310.00	9,172,070.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	330,000.00
210404	Ном, хэвлэл	194,310.00	8,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	725,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	725,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,703,000.00	2,893,000.00

210702	Дотоод албан томилолт	3,703,000.00	2,893,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,024,344.00	10,948,070.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	10,876,570.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	17,544.00	22,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	6,800.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,705,500.00	7,084,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,705,500.00	6,084,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,632,431.89	26,412,886.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,832,000.00	500,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,582,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,250,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,800,431.89	25,912,886.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,800,431.89	25,912,886.88
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>4,090,900.00</u>
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	4,090,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	4,090,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	4,090,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	4,090,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(4,090,900.00)</u>
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	679,000.00	24,877.30	5,093,089.03	5,796,966.33
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	679,000.00	24,877.30	5,093,089.03	5,796,966.33
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	51,114,090.50	51,114,090.50
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	679,000.00	24,877.30	56,207,179.53	56,911,056.83
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	679,000.00	24,877.30	56,207,179.53	56,911,056.83
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	679,000.00	24,877.30	56,207,179.53	56,911,056.83
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(4,564,181.63)	(4,564,181.63)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	679,000.00	24,877.30	51,642,997.90	52,346,875.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	225,911,500.00	199,998,613.12	25,912,886.88	88.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	225,911,500.00	199,998,613.12	25,912,886.88	88.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	214,411,500.00	199,498,613.12	14,912,886.88	93.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,239,000.00	143,718,022.20	2,520,977.80	98.3
210101	Үндсэн цалин	146,239,000.00	88,760,771.99	57,478,228.01	60.7
210102	Нэмэгдэл	-	51,533,257.71	(51,533,257.71)	-
210104	Урамшуулал	-	3,423,992.50	(3,423,992.50)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,279,900.00	18,057,900.92	221,999.08	98.8
210201	Тэтгэврийн даатгал	12,430,300.00	12,279,372.45	150,927.55	98.8
210202	Тэтгэмжийн даатгал	1,462,400.00	1,444,632.10	17,767.90	98.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	731,200.00	722,316.07	8,883.93	98.8
210204	Ажилгүйдлийн даатгал	731,200.00	722,316.07	8,883.93	98.8
210205	Эрүүл мэндийн даатгал	2,924,800.00	2,889,264.23	35,535.77	98.8
2104	Хангамж, бараа материалын зардал	15,880,000.00	12,981,220.00	2,898,780.00	81.8
210401	Бичиг хэрэг	5,160,000.00	3,470,900.00	1,689,100.00	67.3
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	9,172,070.00	827,930.00	91.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	480,000.00	330,000.00	150,000.00	68.8
210404	Ном, хэвлэл	240,000.00	8,250.00	231,750.00	3.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	4,815,900.00	184,100.00	96.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,815,900.00	184,100.00	96.3
2107	Томилолт, зочны зардал	4,522,000.00	2,893,000.00	1,629,000.00	63.9
210702	Дотоод албан томилолт	4,522,000.00	2,893,000.00	1,629,000.00	63.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,400,000.00	10,948,070.00	7,451,930.00	59.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,950,000.00	10,876,570.00	7,073,430.00	60.6

210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	49,500.00	50,500.00	49.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	22,000.00	128,000.00	14.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,000.00	-	200,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,090,600.00	6,084,500.00	6,100.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,090,600.00	6,084,500.00	6,100.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,500,000.00	500,000.00	11,000,000.00	4.4
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,500,000.00	-	10,500,000.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	10,500,000.00	-	10,500,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	500,000.00	500,000.00	50.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	500,000.00	500,000.00	50.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	225,911,500.00	199,998,613.12	25,912,886.88	88.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	225,911,500.00	199,998,613.12	25,912,886.88	88.5
132001	Орон нутгийн төсвөөс	225,911,500.00	199,998,613.12	25,912,886.88	88.53
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	3.00	3.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1.00	1.00	-	100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **954.7** мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд зөрчил таслан зогсоож, арилгуулах 2 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 954.7 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **2,541.5** мянган төгрөгөөс бага, шинж чанарын хувьд материаллаг байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Цахир сумын ИТХ-ын Нарийн бичгийн даргын 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 10 дугаар "Эд хөрөнгийн үзлэг, тооллогын ажлын хэсэг байгуулах тухай" тогтоолоор 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилж, эд хөрөнгийн тооллогыг 2025 оны 12 дугаар сарын 08-аас 15-ны өдрүүдэд зохион байгуулсан байна. Ажлын хэсэг нь тооллогын явцад хурлын тэмдэглэлийг үйлдэж, баталгаажуулаагүй, эд хариуцагчтай хариуцлагын гэрээ байгуулаагүй, хөрөнгийн тооллогыг чанаргүй хийж гүйцэтгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана", Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж, эд хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, журмын дагуу дахин хийж гүйцэтгэн эргэж хянуулах, байгууллагын удирдлагаас тавих хяналтыг сайжруулж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.1.2 Тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл, урамшлыг Нийгмийн даатгалын тайлантай тулган шалгахад 3,202.8 мянган төгрөгийн цалин хөлсийг дутуу тайлагнаснаас 768.7 мянган төгрөгийн НДШ, 186.0 мянган төгрөгийн ХХОАТ нийт 954.7 мянган төгрөгийг өр төлбөр үүсгэж ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гаргахаас өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, НДШ, ХХОАТ-ийн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээг авах албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эд хөрөнгийн тооллогыг чанаргүй хийсэн	1				1	-	-	-				
НДШ, ХХОАТ-ийн нийт 954.7 мянган төгрөгийг төлөөгүй.	1	954.7			1	954.7	-	-				
Нийт дүн	2	954.7			2	954.7						